



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 3, 4, 8 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод үүрэг болгосугай.
- 3.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ

Засгийн газрын 2025 оны 12 дугаар

сарын 03-ны өдрийн 183 дугаар

тогтоолын хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД

ХЯНАЛТ ТАВИХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар (цаашид "хууль тогтоомж, тогтоол, шийдвэр" гэх)-ын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд гарч буй өөрчлөлтийг тодорхой хугацаанд хэмжин, үр дүнг дүгнэхэд оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зарчим

2.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална:

- 2.1.1.шударга, хараат бус байх;
- 2.1.2.нээлттэй, ил тод байх;
- 2.1.3.мэргэжлийн ёс зүйг баримтлах;
- 2.1.4.судалгаа, шинжилгээ, нотлох баримтад үндэслэх;
- 2.1.5.тогтмол, тодорхой үе шаттай байх;
- 2.1.6.талуудын оролцоог хангасан байх;
- 2.1.7.мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;
- 2.1.8.цаг үеэ олсон, үнэн зөв, бодит мэдээллээр хангах;
- 2.1.9.үр дүнг, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага,

зохион байгуулалт

3.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь улсын хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг зохион байгуулахад арга зүйн зөвлөгөө өгөх, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн дүнг мэдээлэхтэй холбоотой ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Энэ журмын 3.1-д заасан чиг үүргийг салбарын хэмжээнд сайд, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын хүрээнд дарга, засаг захиргааны нэгжийн хүрээнд бүх шатны Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжид захирал (дарга) тус тус хариуцна.

3.3.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтантай байх бөгөөд тэдгээр нь зохион байгуулалтын бүтцийн үндсэн, хараат бус нэгж байна.

3.4.Захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж, ажилтан нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг бусад нэгж, харьяа байгууллагаас хүлээн авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид хүргүүлнэ.

3.5.Хамтран хэрэгжүүлэхээр баталсан шийдвэрийн биелэлтийг шийдвэрийн зүйл, заалтад эхэнд нь нэр бичигдсэн байгууллага, албан тушаалтан, Ажлын хэсгийн дарга (ахлагч) нэгтгэн тайлагнана.

3.6.Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, ажилтан нь журмын 3.4-т заасан нэгжээс нэгтгэн ирүүлсэн тайлангийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.

3.7.Монгол Улсын хуулиар эрх олгосон, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл болгосон, үүрэг өгсөн шийдвэрийг Засгийн газарт ирсэн өдөрт нь, Засгийн газрын шийдвэрийг албажуулсан өдөрт нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэгдсэн системд бүртгэн хяналтад авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.8.Энэ журмын 3.2-т заасан албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээнд эрх олгосон, чиглэл өгсөн, үүрэг, даалгавар болгосон шийдвэрийг хяналтад авч, биелэлтийг зохион байгуулж, үр дүнг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнана.

3.9.Шаардлагатай гэж үзвэл дээд шатны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг тухайн байгууллага дээр хянан шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг цаашид боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Засгийн газарт уламжилж болно.

3.10.Энэ журмын 3.9-д заасан хяналт шалгалтын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хүргүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтан арга хэмжээ авч, эргэн мэдэгдэнэ.

3.11.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

3.12.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнахад эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах зардлыг тухайн байгууллага хариуцна.

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалтанд

тавих шаардлага, эрх, үүрэг

4.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажилтан дараах мэргэшлийн шаардлагыг хангасан байна:

4.1.1.хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр, эсхүл тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

4.1.2.хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

4.1.3.баримт бичигт дүн шинжилгээ хийх чадвартай байх.

4.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалтан дараах эрхтэй:

4.2.1.хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт бичгийг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах, танилцах;

4.2.2.хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

4.2.3.эрхлэх асуудлын хүрээний байгууллага, албан тушаалтанд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, гарын авлага бэлтгэх;

4.2.4.хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

4.3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалтан дараах үүрэгтэй:

4.3.1.хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах;

4.3.2.чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж авсан баримт бичиг, мэдээллийн нууцыг хадгалж, зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд ашиглах;

4.3.3.хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хууль тогтоомж, баримт нотолгоонд үндэслэн гаргах;

4.3.4.мэргэжил, мэдлэг, ур чадвараа тогтмол хөгжүүлэх.

Тав.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг

тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

5.1.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн явцыг улирал тутам, үр дүнг хагас, бүтэн жил, зөвлөмжийн биелэлтийг жилийн эцэст энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд 2, 3 дугаар хавсралтын дагуу дээд шатны байгууллагад тайлагнана.

5.2.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь хуулиар эрх олгосны дагуу захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт батлан гаргасан эсэх тайланг хагас, бүтэн жилээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

5.3.Төрийн захиргааны төв байгууллага салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу 5 жил тутамд үр дагаврын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

5.4.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацаа болон байгууллага, иргэдээс хуулийн хэрэгжилттэй холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг дүнг үндэслэн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх төлөвлөгөөг энэ журмын 4 дүгээр хавсралтаар гаргаж, хагас, бүтэн жилийн тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

5.5.Энэ журмын 3.5-д заасан хамтран хэрэгжүүлсэн шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ахлан гүйцэтгэх албан тушаалтан нь холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнана. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага нь биелэлтийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанаас 10 хоногийн өмнө нэгтгэн, тайлагнах байгууллагад хүргүүлсэн байна.

5.6.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн явц, үр дүнд энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд, 2, 3, 4 дүгээр хавсралтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна.

5.7.Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн, дүгнэлт, зөвлөмжийг "Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-ын дагуу энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

5.8.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.9.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу хяналтаас хасуулах шийдвэр, заалтыг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлнэ.

5.10.Улсын төсөвт байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээд хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд биелэлтэд нь холбогдох төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага хяналт тавьж, нэгтгэн тайлагнана.

5.11.Шаардлагатай тохиолдолд энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанаас үл хамаарч хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд салбар, чиглэл, агуулгаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авч болно.

5.12.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж дараах шаардлагыг хангасан байна:

5.12.1.цаг үеэ олсон, нотлох баримттай, үнэн зөв, бодитой, иж бүрэн, үр дүнд суурилсан байх;

5.12.2.биелэлт хангалтгүй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан;

5.12.3.чанарын болон тоон мэдээллийн үр дүнг агуулсан;

5.12.4.биелэлтийн үр дүн хоёр мянган тэмдэгтэд багтсан товч, тодорхой байх.

Зургаа.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй

6.1.Хуулийн биелэлтийг энэ журмын 5.2-5.4-т зааснаар тайлагнана.

6.2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн явц, үр дүнг дараах аргачлалын дагуу дүгнэнэ:

6.2.1."Хэрэгжсэн"-биелэлт бүрэн хангагдсан, нотлох баримтыг бүрэн хавсаргасан бол "100 хувь";

6.2.2."Хэрэгжих шатанд"-төсөв, санхүүгийн асуудлыг шийдэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарсан, удирдах дээд шатны байгууллагад өргөн барьсан бол доор дурдсан шатлалаар "50 хувь":

-тодорхой үр дүнд хүрсэн;

-удаашралтай/эрчимжүүлэх шаардлагатай.

6.2.3."Хэрэгжээгүй"-шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил хийгдэж дууссан ч төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй, хугацаа хоцорсон, биелүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол доор дурдсан шалтгаанаас хамаарсан "0 хувь":

-зохион байгуулалтаас;

-санхүү, хөрөнгө оруулалтаас.

6.2.4."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй"-хэрэгжүүлэхээр заасан хугацаа болоогүй, урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай болон өөрөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бусад хүчин зүйлээс шалтгаалан биелэлт бүрэн хангагдаагүй бол "ХБ";

6.2.5."Хэрэгжих боломжгүй"-хуулиар эрх олгосон, бусад шийдвэрээр чиглэл өгсөн, үүрэг, даалгавар болгосон шийдвэр, зүйл, заалт доор дурдсан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд:

-хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй;

-хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй;

-хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй;

-хийх ажил, зорилго тодорхойгүй;

-хэмжигдэхүйц биш.

6.3.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн нэгдсэн дүнг гаргахдаа дараах томьёоны дагуу тооцно:

$$\text{Хэрэгжилтийн хувь} = \frac{\text{Хэрэгжсэн заалтын тоо} \cdot 100\% + \text{Хэрэгжих шатанд буй заалтын тоо} \cdot 50\%}{\text{Нийт заалтын тоо} - \text{Хугацаа болоогүй заалтын тоо} - \text{Хэрэгжих боломжгүй заалтын тоо}}$$

6.4.Дараах тохиолдолд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтаас хасах тухай саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ:

6.4.1.бүрэн хэрэгжсэн;

6.4.2.бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон;

6.4.3.цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон;

6.4.4.тухайн шийдвэр хүчингүй болсон;

6.4.5.шийдвэрт заасан хугацаа дууссан;

6.4.6.тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан;

6.4.7.чиг үүрэгт хамааралгүй.

6.5.Үр дагавар нь үргэлжлэх, байнгын шинжтэй, тогтмол мөрдөх шийдвэр, заалтыг байгууллага дотоод хяналтдаа авч, Засгийн газрын нэгдсэн системийн хяналтаас хасуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.6.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ журмын 6.4-т заасан саналыг хянаж, үндэслэлтэй гэж үзвэл зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанд танилцуулах бөгөөд Засгийн газрын шийдвэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.7.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилт хоёр удаагийн тайлангийн хугацаанд ахиц гараагүй бол тасарсанд тооцож, шалтгаан нөхцөлийг тодорхойлох бөгөөд давхардал, хийдэл, зөрчлийг илэрсэн тохиолдолд хууль, журамд нийцүүлэн өөрчлөх, хүчингүй болгох санал боловсруулж, дээд шатны байгууллагад уламжилна.

6.8.Улсын Их Хурлын тогтоолын хавсралтаар баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам" болон 2 дугаар хавсралтаар баталсан "Үнэлгээ хийх журам"-аар хяналт-шинжилгээ хийж, үнэлнэ.

Долоо.Нэгдсэн систем

7.1.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтад

авах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан илгээх, хүлээн авах, дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх нэгдсэн системийг ашиглана.

7.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд нэгдсэн системийн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.2.1.системийн хэвийн, найдвартай ажиллагаа болон эрхийн зохицуулалт;

7.2.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрээр өгсөн үүрэг, даалгаврыг бүртгэх, хяналтад авах, хяналтаас хасах, хэрэгжилтийн явц, үр дүнг журмын хугацаанд тайлагнах, тайланг хүлээж авах, байгууллагын болон нэгдсэн тайланд хяналт-шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх;

7.2.3.нэгдсэн системийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх.

7.3.Нэгдсэн системд мэдээлэл оруулж, баталгаажуулж байгаа байгууллага, албан тушаалтан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

7.4.Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны холбогдох албан тушаалтан болон бусад байгууллагын удирдлага хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцах зорилгоор нэгдсэн системийг ашиглаж болно.

7.5.Нэгдсэн систем нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд зориулсан хэсэгтэй байх бөгөөд үр дүнгийн статистик, график мэдээг байршуулна.

7.6.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа шийдвэртэй давхардал, хийдэл, зөрчил гаргахгүй байх зорилгоор өмнөх шийдвэрийн хэрэгжилт, үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг харгалзан үзнэ.

7.7.Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд ажлаа тайлагнахад мэдээллийн эх сурвалж болгоно.

Найм.Хяналт-шинжилгээ, үнэлгээний

үр дүнг хэрэгжүүлэх

8.1.Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн энэ журмын 6.4-т заасан шийдвэр, заалтыг мэдээллийн нэгдсэн системийн хяналтаас хасна.

8.2.Сайд, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын дарга, тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга (захирал) зөвлөмжөөр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг салбар, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд зохион байгуулж, биелэлтийг хангуулна.

8.3.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр "Хэрэгжүүлээгүй", "Хэрэгжих шатанд" байгаа шийдвэр, заалтын биелэлтийг эрчимжүүлэх талаарх дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллана.

8.4.Хяналт-шинжилгээний нэгдсэн дүнгээр хангалтгүй үнэлэгдсэн байгууллагад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.5.Энэ журмын 6.7-д заасан нь үндэслэлтэй гэж үзвэл шийдвэр, зүйл, заалтад өөрчлөлт оруулах саналыг Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

Ес.Хариуцлага

9.1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн нэгдсэн дүнгээр "хангалтгүй" үнэлэгдсэн сайд, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын дарга, тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн захирал (дарга)-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Мэдээллийн үнэн зөв байдлыг хангаагүй, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, дээд шатны байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага тооцно.

---o0o---

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн

биелэлтэд хяналт тавих нийтлэг

журмын 1 дүгээр хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлангийн төрөл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлэх байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	Тайлан хүлээн авах байгууллага	Давт амж	Тайлагнах байгууллага, хугацаа
1	2	3	4	5	6	7

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт	Монго л Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчий н зарлиг, ҮАБЗ-ийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, шийдвэр	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	0 07.0 1	01.1 06.1	ЗГХЭГ	Явц ыг улирал тутам цахимаар.	Засгийн газарт 3, 9 дүгээр сард танилц уулна УИХ, Ерөнхийлөгчи йн Тамгын газар, ҮАБЗ- ийн Ажлын албанд 4, 9 дүгээр сард
		Засгийн газрын агентлаг	5 06.1 0	01.0 06.1	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба		
		Төрийн өмчит хуулийн этгээд, улсын төсөвт үйлдвэрийн газар	5 06.1 0	01.0 06.1	Салбар ын яам болон, агентлаг		
		Аймаг, нийслэлийн Засаг дарга	0 07.0 1	01.1 07.0	ЗГХЭГ		

*Явцыг улирал тутам цахим системээр тайлагнана.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн

биелэлтэд хяналт тавих нийтлэг

журмын 2 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ

ТАЙЛАГНАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ САЛБАР, ЧИГЛЭЛ

Нэг.Төрийн үйлчилгээ

-Боловсрол

-Эрүүл мэнд

-Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

-Соёл

Хоёр.Дэд бүтэц, бүтээн байгуулалт

-Инженер, дэд бүтэц

-Нийгмийн дэд бүтэц

-Уул уурхай, хүнд үйлдвэр

-Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэр

-Мал аж ахуй, газар тариалан

-Төсөл, хөтөлбөр

-Техник, тоног төхөөрөмж

Гурав.Засаглал

-Эрх зүйн орчин

-Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

-Мэдээллийн технологи хөгжүүлэлт, нэвтрүүлэлт

-Санхүү, хөрөнгө оруулалт, экспорт, импорт

-Төрийн мэдээллийн ил тод байдал

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ САЛБАР, ЧИГЛЭЛЭЭР ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

		Зү йл, заалтын дэс дугаар	Би елэлт	Үнэлгээ /Шалтгаан/						Хэрэг боломжгүй	Хяналтаас хасуулах тухай санал
				Х эрэгжсэн	Хэрэгжих шатанд		Хэрэгжээгүй		Х угацаа болоогүй		
					тодорхой үр дүнд хүрсэн	удаашралтай/ эрчимжүүлэх шаардлагатай	зохион байгуула лтаас	хөрөнгө дутагдсанаас			
1.а.Монгол Улсын хууль /баталсан хэм хэмжээний акт/											
1.б.Улсын Их Хурлын тогтоол											
1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол											

1.г.Ерөнхийлөгчийн зарлиг
1.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл
1.е.Засгийн газрын тогтоол
1.ё.Ерөнхий сайдын захирамж
1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
1.з.Ерөнхий сайдын албан даалгавар
Хэсгийн дундаж: хувь
2.а.Монгол Улсын хууль...
Хэсгийн дундаж: хувь
Нийт дундаж: хувь

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн

биелэлтэд хяналт тавих нийтлэг

журмын 3 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ САЛБАР, ЧИГЛЭЛЭЭР ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ХҮСНЭГТ

			үгд	Үүнээс								
				Ху уль /баталсан	Х-ын тогтоол	УИ Х-ын Байнгын хорооны тогтоол	УИ Ерөнхийлөгчий н зарлиг	ҮА БЗ-ийн зөвлөмж	ҮА БЗ-ийн хуралдаан ы тэмдэглэл	За сгийн газрын тогтоол	Ер өнхий	За сгийн газрын хуралдаан ы тэмдэглэл
НЭГ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ												
Боловсролын үйлчилгээ												
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо												
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо												
Үнэлгээ	Хэрэгжсэн											
	хэрэгжих шатанд	Т одорхой үр дүнд хүрсэн										
		У даашралт ай/эрчимжүүлэх шаардлагатай										
	хэрэгжээгүй	З охион байгуулалтаас										
		Х өрөнгө дутагдсан аас										
	Хугацаа болоогүй											
	Хэрэгжих боломжгүй											
	Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/											
Дүн /хувь/												

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн

биелэлтэд хяналт тавих нийтлэг

журмын 4 дүгээр хавсралт

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Салбар/байгууллага	Хуулийн нэр, огноо	Үнэлгээ хийх үндэслэл		Үнэлгээний төрөл		Хугацаа		Үнэлгээ хийх төсөв	Санхүүжилтийн эх үүсвэр
			хуулийн хугацаа	байгууллага, иргэдээс ирсэн саналын дүн	бүхэлд нь	зүйл, хэсэг,	эхлэх	уусах		
-										
-										
Дүн										

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАНГИЙН ДҮН

	Салбар / байгууллага	Хуул ийн нэр, огноо бүхэлд нь/	Үнэлгээ хийх үндэслэл		Үр дагаврын үнэлгээний дүн				Үнэлгээ хийгээгүй		Тай лбар
			хуулийн хугацаа болсон	байгууллага, иргэдээс ирсэн саналын дүн	үр дүнтэй хэрэгжсэн	өөрчлөлт оруулах	шинэчлэн найруулах	зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгох	зохион байгуулал таас	санхүүжи лт дутагдсан аас	
.											
.											
	Дүн										